

## **ТӨМӨР ЗАМЫН ЗАМЫН ДЭЭД БҮТЭЦ БАРИХ БАРИЛГЫН АЖЛЫН ТӨСӨВ ЗОХИОХ ДҮРЭМ**

**ТЗНБД 01-II-04-2020**

### **НЭГ. ТӨМӨР ЗАМЫН ЗАМЫН ДЭЭД БҮТЭЦ БАРИХ АЖЛЫН ТӨСӨВ ЗОХИОХ ДҮРЭМ**

#### **Ерөнхий зүйл**

1.1. Энэхүү аргачлал нь батлагдсан ажлын зураг, төсвийн нормыг үндэслэн төмөр замын замын дээд бүтцийн барих ажлын өртгийг тодорхойлох зарчмыг баримтлана.

1.2. Энэ дүрмийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт төмөр замын замын дэд бүтцийг шинээр болон шинэчлэн барьж угсрах, өргөтгөх, засварлах ажлын өртгийг тодорхойлоход баримтлах арга зүй, зарчим, дарааллыг тогтоон зохицуулна.

1.3. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, Монгол Улсыг хөгжүүлэх сан, дотоод, гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламж болон тэдгээртэй адилтгах бусад эх үүсвэрээр санхүүжигдэх төмөр замын замын дээд бүтэц барих ажлын төсөв тооцоо хийхэд өмчлөлийн хэлбэр, харьяаллаас үл хамааран энэ дүрмийг мөрдөн баримтлана.

1.4. Энэхүү дүрмийг Монгол Улсад мөрдөгдөж байгаа хууль тогтоомж, Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан салбарын үнэ бүрдэл, төсвийн норм, норматив, төмөр замын тээврийн нийтлэг дүрэм, журам, эрх зүйн бусад баримт бичгийг үндэслэн боловсруулж, замын дээд бүтэц барих ажлын төсвийн нормчлол, үнэ бүрдлийн харилцааг зохицуулна.

### **ХОЁР. ТӨМӨР ЗАМЫН САЛБАРЫН ҮНЭ БҮРДЭЛ, ТӨСВИЙН НОРМЫН НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

2.1 Төмөр замын замын дээд бүтэц барих ажлын төсвийн нормчлол, үнэ бүрдлийн тогтолцоо нь дээд бүтцийн барилгын ажлын төсөвт өртгийг тодорхойлоход зайлшгүй шаардлагатай төсвийн норм, нормативууд, холбогдох аргачлал, заавар бусад баримт бичгүүдийг /цаашид төсвийн норматив гэх/ өөртөө агуулах зарчимтай байна.

2.2 Төсвийн норматив гэдэг нь тусгай эмхэтгэлд нэгтгэсэн төсвийн иж бүрэн норм норматив, үнэ, жишиг үнийн бүрдэл байна. Төсвийн нормативууд нь холбогдох бусад аргачлал, заавар, журмын хамтаар дээд бүтэц барих ажлын төсөвт өртгийг тодорхойлох үндэс болно.

2.3 Төмөр замын замын дээд бүтэц барьж угсрах ажлын нэгж хэмжигдэхүүнд тогтоосон нөөцийн хэмжээг /ажиллах хүчний хөдөлмөр зарцуулалт, төмөр замын зам барилга, засварын машин механизм, гол зам болон сэлгээний зүтгүүр, тусгай зориулалтын хөдлөх бүрэлдэхүүн, бусад зам барилгын машин механизмын ажиллах хугацаа, материал, хийц, эдлэхүүний хэрэгцээ/ төсвийн норм гэж нэрлэж зохицуулна.

2.4 Төсвийн нормын үндсэн зориулалт нь тухайн төрлийн ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай, хүрэлцэхүйц хэмжээний нормативд нөөцийн хэмжээг тогтоох, үүний үндсэн дээр өртгийн үзүүлэлтийг тодорхойлно.

2.5 Төсвийн нормативыг холбогдох төмөр замын норм ба аргачлал, стандарт, технологийн дагуу төмөр замын замын дээд бүтэц барих ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүх нөөцийн хэрэгцээг үндэслэн боловсруулах зарчмыг баримтлана.

2.6 Төсвийн нормыг гаднын хүчин зүйлс нөлөөлөхгүй, хэвийн /стандарт/ нөхцөлд тухайн ажлыг гүйцэтгэхээр боловсруулна. Хэрэв онцгой нөхцөлд /төслөгдсөн төмөр замын удирдах хэвгий их, газарзүйн байрлал, цаг агаарын нөхцөл/ ажил гүйцэтгэвэл төсвийн нормд илтгэлцүүр хэрэглэх бөгөөд түүний хэмжээ, ашиглах нөхцөлийг төсвийн нормын холбогдох эмхэтгэлийн ерөнхий /техникийн/ хэсэг, хөдөлмөр зарцуулалт ба машин механизмын лавлахад тодорхойлсон байдлаар зохицуулна.

2.7 Хүчин төгөлдөр мөрдөж байгаа төсвийн нормын эмхэтгэлд зураг төсөлд тусгагдсан технологиор ажлыг гүйцэтгэх норм байхгүй бол тухайн ажлын төсвийн нормыг зураг төслийн ажлын бүрэлдэхүүнд боловсруулж, захиалагч /хөрөнгө оруулагч/ байгууллагаар батлуулж мөрдөхөөр зохицуулна.

2.8 Төмөр замын суурь бүтэц эзэмшигч байгууллага өөрийн эзэмшлийн төмөр зам болон төмөр замын сүлжээг нэмэгдүүлж шинээр барих, шинэчлэх, засварлах зэрэг ажлыг өөрийн ажиллах хүч, машин механизм, хөрөнгөөр гүйцэтгэхээр бол байгууллагын төсвийн нормыг хэрэглэх зарчмыг баримтлана.

2.9 Төсвийн суурь нормын эмхэтгэл нь техникийн хэсэг, төсвийн нормын хүснэгт, хавсралт лавлахтай байна. Техникийн хэсэгт төсвийн нормын эмхэтгэлүүдийг хэрхэн хэрэглэх заавар, ажил гүйцэтгэх нөхцөлийг харгалзан төсвийн нормд илтгэлцүүр хэрэглэх журам, түүнчлэн ажлын тоо хэмжээг хэрхэн тодорхойлох зааврын талаар зааж зохицуулна.

2.10 Төсвийн суурь нормын хүснэгт, хавсралт лавлах нь дараах нөөцүүдийн норматив үзүүлэлтүүдийг агуулсан байх ба үүгээр зохицуулна. Үүнд:

- a) Үндсэн ажлын дундаж зэрэг;
- b) Ажлын дундаж зэргийн хөдөлмөр зарцуулалт, /хүн.цаг/;
- c) Төмөр замын Зам барилгын машин механизм, гол замын болон сэлгээний зүтгүүр, тусгай зориулалтын хөдлөх бүрэлдэхүүн, механикжсан багаж, тоноглол, хэрэгслийн бүрэлдэхүүн, ажиллах хугацаа, /машин.цагаар/;
- d) Ажил гүйцэтгэхэд хэрэглэх материал, хийц, эдлэхүүний нэр төрөл, тэдгээрийн биет хэмжих нэгжээр илэрхийлэгдсэн зарцуулалт, хэмжих нэгжийн цэвэр жингийн хэмжээ;

2.11 Байгууламж, объектыг галт тэрэгний хөдөлгөөн нээх байдалд хүлээлгэн өгөх, тохируулга, зүгшрүүлэх ажлыг дараах нөхцөлийн төсвийн нормын эмхэтгэлд тусгаж зохицуулна. Үүнд:

- a) ажиллах хүчний тоо, хөдөлмөр зарцуулалт /хүн.цагаар/
- b) материалын зарцуулалт;
- c) ашигласан зам барилгын машин механизм, гол замын болон сэлгээний зүтгүүр, тусгай зориулалтын хөдлөх бүрэлдэхүүн, хэмжин-шалгах хөдлөх бүрэлдэхүүн, багаж хэрэгслүүд;

2.12 Дээрх зардлуудыг зураг төслийн өгөгдлүүдийг үндэслэн тодорхойлно.

2.13 Томсгосон норм, үнэлгээг төсвийн суурь нормыг үндэслэн боловсруулна.

### **ГУРАВ. ТӨМӨР ЗАМЫН ТӨСӨВ ЗОХИОХ ДҮРЭМ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ, БАРИМТ БИЧГИЙН БҮТЭЦ**

3.1 Зураг төслийн баримт бичгийн бүрдэл хэсгийг барилгын ажлын төсвийг төсвийн суурь норм болон цалингийн тариф, машин механизм ашиглалтын тариф, тээврийн тарифт үндэслэн боловсруулж, харилцааг зохицуулна. Нэгж өртгийг боловсруулж болно.

3.2 Төмөр зам барих зураг төслийн баримт бичгийг үндэслэж тооцсон, төмөр замын замын дээд бүтэц барихад шаардагдах нийт мөнгөн хөрөнгийн нийлбэрийг төсөвт өртөг гэнэ.

3.3 Төмөр замын замын дээд бүтэц барих ажлын төсөвт өртөг нь хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлох, гэрээний үнийг тогтоох, гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын тооцоог хийх, тоног төхөөрөмж авах, түүнийг барилга байгууламж, объектод хүргэх зардлыг төлөх, түүнчлэн төсөвт тусгагдсан бусад зардлуудыг санхүүжүүлэх үндсэн баримт бичиг болгон авч зохицуулна.

3.4 Төмөр замын замын дээд бүтэц барих ажлыг батлагдсан зураг төслийн дагуу гүйцэтгэнэ. Батлагдсан зураг төслийг үндэслэн төсвийн тооцоог хийх ба тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа норм дүрмийг баримтлан тооцно.

3.5 Өртгийг тодорхойлох нөөцийн арга гэж төсвийн суурь нормд тусгагдсан барилгын ажлын хэмжих нэгжид харгалзах хөдөлмөр зарцуулалт, материал, бүтээц эдлэхүүний биет хэрэгцээ, тэдгээрийн хэмжих нэгжийн цэвэр жин, Төмөр замын тээврийн салбарын зам, барилгын машин механизм, гол замын болон сэлгээний зүтгүүр, зориулалтын хөдлөх бүрэлдэхүүн, механикжсан багаж, тоноглол, хэрэгсэл бүрэлдэхүүний ажиллах ашиглалтын хугацааны үзүүлэлтийг үндэслэн хэрэгцээт нөөцийн хэмжээг тодорхойлж, тухайн үеийн үнэ, тарифыг хэрэглэн төсөв зохиож эдгээрийн харилцааг зохицуулна.

3.6 Төсвийн баримт бичгийг бүрдүүлэхдээ дараах дэс дарааллыг баримтална. Үүнд:

**а) Бэлтгэл ажил:**

- Барилга байгууламжийн зураг төсөлтэй танилцах;
- Батлагдсан ажлын тоо хэмжээг үндэслэн тооцоо гаргах;
- Илтгэлцүүрүүдийг ажлын ямар онцлог нөхцөлд ашиглахыг тогтоож, тооцоонд хэрэглэх;
- Тухайн төсвийн тооцоонд хэрэглэгдэх жишиг үнэ, тариф, эрх зүйн баримт бичгүүдийг бүрдүүлэх.

## **б) Төсвийн тооцоог хийхэд баримтлах зарчим:**

### ***Шууд зардал***

- Ажиллах хүчний хөдөлмөр зарцуулалт, цалингийн тооцоо;
- Инженер техникийн ажилтнуудын цалингийн тооцоо;
- Ажилтны нэмэгдэл цалин /илүү цаг, амралт, баяр ёслолын өдөр, шагнал урамшуулал, ээлжийн амралт, өвөл цагийн ажилгүй байсан үеийн, цаг агаарын саатал, сул зогсолтын цалин, даатгал болон харуул хамгаалалтын цалин гэх мэт/-гийн тооцоо;
- Цалингаас бодох эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоо;
- Материал, хийц, эдлэлийн хэрэгцээ, хүндийн жингийн тооцоо;
- Материалын үнийн тооцоо;
- Материалын тээврийн зардлын тооцоо;
- Машин механизм ашиглалт /машин.цаг/-ын хэрэгцээ, зардлын тооцоо;

### ***Нэмэлт зардал:***

- Удирдлага, зохион байгуулалтын зардлын тооцоо
- Түр барилга байгууламжийн зардал
- Албан томилолтын зардал
- Ажилчдын байр, хоол үйлчилгээний зардал
- Хөдөлмөр хамгааллын хувцас, ажлын багаж хэрэгслийн зардлын тооцоо;
- Бусад ажил болон зардал
- Төсөвт ашгийн тооцоо.

## **в) Төсөв зохиох ажлыг гүйцэтгэх:**

- Нэгдсэн төсвийн тооцоо хийх;
- Төсвийн тооцооны товч тайлбар бичиг бичих.

## **ДӨРӨВ. ТӨСВИЙН БАРИМТ БИЧИГ ЗОХИОХ**

4.1. Төмөр замын дээд бүтцийн ажлын өртөг нь шууд зардал, нэмэгдэл зардал, төсөвт ашиг гэсэн бүрэлдэхүүнтэй байхаар зохицуулсан.

4.1.1. Шууд зардалд ажлыг гүйцэтгэхэд зайлшгүй хэрэгцээтэй дараах зардлыг тооцно:

- Материалын /материал, хийц, эдлэхүүн/;
- Машин, механизмын ашиглалтын;
- Цалингийн зардал

- Инженер техникийн ажилтны цалин;
- Тээврийн зардал /материалын нөөцийг ажлын талбайд хүргэх/;
- Ажилтны нэмэгдэл цалин /илүү цаг, амралт, баяр ёслолын өдөр, шагнал урамшуулал, ээлжийн амралт, өвөл цагийн ажилгүй байсан үеийн, цаг агаарын саатал, сул зогсолтын цалин, даатгал, болон харуул хамгаалалтын цалин гэх мэт/;
- Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллага хариуцан төлөх хэсэг;

4.1.2. Нэмэлт зардалд удирдлага, зохион байгуулалтын, хөдөлмөр хамгаалал эрүүл ахуй, ажилчдын байр, хоол, үйлчилгээ, түр барилга байгууламж, албан томилолт, зохион байгуулалтын үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдсон зардлууд даатгал, томилолтын зардал, зам барилгын ажил гүйцэтгэхтэй холбогдон гарах нэмэлт зардал гэх мэт гарах байгууллагын зардлуудыг тооцно.

## ТАВ. ШУУД ЗАРДАЛ

### Цалингийн зардал:

5.1 Ажиллах хүчний хөдөлмөр зарцуулалтыг Төмөр замын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан барилгын ажилтны тарифт цалингийн жишгээр үржүүлж, төсөвт тусгагдсан ажилтны үндсэн цалингийн хэмжээг тодорхойлон баримтлана.

5.2 Төсвөөр тооцож гарсан ажиллах хүчний үндсэн цалингийн дүнгээс инженер техникийн ажилтны цалинг 17% хувиар, ажилтны ээлжийн амралт, шагнал урамшуулал, нөхөн олговор, нэмэгдэл цалинг 37%-аар, машин механизмын операторчдын цалинг механизмын зардлын 3%-аар тус тус тооцож мөрдөнө.

5.3 Төмөр замын зам, барилгын ажил хийгдэх барилга байгуулам, объектыг улсын нийслэл ба аймгийн төвөөс алслагдсан зайнаас хамаарах ажилчдын нэмэгдэл цалинг Засгийн газрын гишүүний баталсан тушаалыг баримтлан тооцож зохицуулна. Үүнд:

а) Улаанбаатар хотоос нүүлгэн ажиллуулах тохиолдолд нийт цалингийн сангаас тооцон, нэмж олгох алслалын нэмэгдлийн илтгэлцүүр нь:

### Улаанбаатар хотоос нүүлгэн ажиллуулах тохиолдолд цалинг нэмэгдүүлэх илтгэлцүүр

1-р хүснэгт

Тойргийн хүрээ	Улаанбаатар хотоос алслагдсан тойргийн хэмжээ, км-ээр	Цалинг нэмэгдүүлэх илтгэлцүүр
I	300 хүртэл	1.0
II	301-600	1.38
III	601-900	1.43
IV	901-1200	1.49
V	1201-1500	1.60
VI	1501-ээс дээш	1.71

б) Аймаг төвтэй орон нутагт нүүлгэн ажиллуулах тохиолдолд нийт цалингийн сангаас тооцон, нэмж олгох алслалын нэмэгдлийн илтгэлцүүрээр зохицуулна.

**Аймгийн төвөөс алслагдсан тойрогт цалинг  
нэмэгдүүлэх илтгэлцүүр**

2-р хүснэгт

Тойргийн хүрээ	Аймгийн төвөөс алслагдсан тойргийн хэмжээ, км-ээр	Цалинг нэмэгдүүлэх илтгэлцүүр
I	100 хүртэл	1.0
II	101-200	1.36
III	201-300	1.61
IV	301-ээс дээш	1.71

5.4 Нийт цалингийн хэмжээг төсөвт тусгагдсан ажилтнуудын үндсэн цалин, инженер техникийн ажилтны цалин, нэмэгдэл цалингийн нийлбэрээр тогтооно. Нийт цалингийн дүнгээс мөрдөгдөж байгаа хуулийн дагуу нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын байгууллага хариуцан төлөх шимтгэлийн хэмжээг тодорхойлж зохицуулна.

5.5 Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа “Төмөр замын замын дээд бүтэц барих ажлын ажилтны цагийн тарифт цалин”-г барилга байгууламжийн төсвийн цалингийн тооцоонд хэрэглэнэ. Засгийн газраас төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн үед тухайн жилийн батлагдсан цалингийн индексийн өсөлтийн хувиар жишиг тарифт цалинг өсгөж тооцох зарчмыг баримтлана. Цалингийн тариф болон дундаж зэргийн бутархай утгад харгалзах цагийн тарифт цалинг хавсралт-3-р хүснэгтэд үзүүлэв.

5.6 Ажилчдын хөдөлмөр зарцуулалт, цалингийн зардлын тооцоог хийхэд 1-р маягтын дагуу гүйцэтгэнэ.

**Материал:**

5.7 Төсвийн суурь нормын материалын лавлахад нормын шифр /үндэслэл/-ийн дагуу тухайн ажилд шаардлагатай материал, эдлэхүүн, бүтээцийн хэрэгцээт нөөцийг нэр төрлөөр нь тусгаж, материалын хэмжих нэгж, хэмжих нэгжийн цэвэр жинг заасныг баримтлана.

5.8 Төсвийн тооцооны материалаас нэмэгдсэн өртгийн албан татварыг хасаж материалын зардлын тооцоонд оруулж зохицуулна.

5.9 Төсвийн суурь нормоор гарсан материал, эдлэхүүн, бүтээцийн нормативд хэрэгцээг нэр төрлөөр нь нэгтгэж гаргаад тээврийн тооцоогоор зохицуулна. **Төмөр замын замын дээд бүтцийн үндсэн материал болох зам төмөр, бетон дэр, чигжээсний материал, уулзварын хавчаар боолт, суман шилжүүлэг, түүний дүнг зэрэг материалын үнийг тогтоосон тарифаар тооцох зарчим баримтлана.**

5.10 Төмөр замын замын дээд бүтцийн үндсэн материал болох зам төмөр, бетон дэр, чигжээсний материал, уулзварын хавчаар боолт, суман шилжүүлэг, түүний дүнг зэрэг материалын үнийн дүнг төсөвт оруулж тооцохгүйгээр зохицуулна. Материалын тооцоог хийхэд 2-р маягыг ашиглан гүйцэтгэнэ.

## Тээвэр:

5.11 Нийт материалын хэрэгцээгээр тээврийн зардлыг тооцоог баримтлана.

5.12 Төмөр замын тээврээр бол тээвэрлэгчийн ачаа тээврийн тарифыг ашиглана. Авто тээврээр бол Зам, тээврийн хөгжлийн сайдын баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Авто тээврийн жишиг тарифыг ашиглан зардлыг тооцож зохицуулна.

5.13 Материал, эдлэхүүн, бүтээцийн тээвэрлэх хүндийн жин, вагоны тоог олсны дараа тээвэрлэх зайн хэмжээ, ачааны бүлэг, зэргийг тогтоон тээвэрлэгчийн тогтоосон тариф болон тонн/км-ын тарифаар үржүүлэн тээврийн зардлыг тооцож зохицуулна.

5.14 Төмөр замаар тээвэрлэх ачаанд тээвэрлэж байгаа байгууллагын баталсан тээврийн зай /ажлын талбай дахь/, ачааны бүлгээс хамааруулсан нийтэд үйлчлэх вагон тээврийн тарифыг сонгон хэрэглэх зарчмыг баримтлана.

5.15 Материалын тээврийн зардлын тооцоог хийхэд 3.1-р маягтын дагуу гүйцэтгэнэ. Нүүлгэн шилжүүлэх зардлын тооцоог 5-р маягтын дагуу гүйцэтгэнэ.

### **Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг тодорхойлох**

5.16 Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын зардлыг төсвийн суурь нормоор тооцож гаргасан машин механизмын ажиллах хугацаа /машин.цаг/ болон 1 машин.цагийн үнийг үндэслэн тодорхойлсныг баримлана.

5.17 Засгийн газрын гишүүний баталсан 1 маш/цагийн тарифыг 2-р хавсралт, Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн ашиглан задгай ачааны ачилт, буулгалтын тарифыг 3-р хавсралтын дагуу тус тус тооцож зохицуулна.

5.18 Төсвийн тооцоогоор гарсан машин цагийн хэрэгцээг нэр төрлөөр нь нэгтгэн жагсааж гаргаж, жагсаалтаар гарсан машин цагийн нийт хэмжээг тохирох машин цагийн үнээр үржүүлж машин механизмын зардлыг тодорхойлно. Төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан нормоор 1 машин цагийн үнийг машины нэр төрөл, хүчин чадлаар тогтоож харилцааг зохицуулна.

5.19 Онцгой төвөгтэй, хүчтэй, том оврын машиныг нүүлгэн шилжүүлэхэд гарах зардлын төсвийг тусгайлан тооцож гаргана. Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалтын /машин.цаг/-ын зардлын тооцоог боловсруулахдаа 4-р маягтыг ашиглан тооцож мөрдөнө.

## **ЗУРГАА. НЭМЭЛТ ЗАРДАЛ**

### **6.1 Удирдлага, зохион байгуулалтын зардал:**

6.1.1 Удирдлага, зохион байгуулалтын зардалд гүйцэтгэгч байгууллагын тухайн объектыг удирдлагаар хангаж бусад оролцогч байгууллагуудын уялдааг хангах, зохион байгуулалтын үйл ажиллагааг хэвийн явуулахтай холбогдсон зардлууд, хүйтний улиралд барилга угсралтын ажил гүйцэтгэхтэй холбогдон гарах нэмэлт зардал багтана. Удирдлага, зохион байгуулалтын зардлын нормативыг төсөвт тусгагдсан нийт цалингийн дүнгээс 63.5% хувиар тогтооно.

## **6.2 Түр барилгын зардал**

6.2.1 Төсөвт тусгагдсан хөрөнгөөр гүйцэтгэж буй түр барилга байгууламж нь гүйцэтгэгч байгууллагын мэдлийн хөрөнгө болно.

6.2.2 Төсөвт тусгагдсан түр барилгын зардалд ажил гүйцэтгэх болон ажиллагсдын үйлчилгээнд шаардлагатай түр барилгын/ажилчид байрлах кемп, түр агуулах г.м/ зардал багтана. Төсөвт тусгагдсан түр барилгын зардлын нормыг шууд зардлын дүнгээс материалын зардлыг хассан дүн болон удирдлага, зохион байгуулалтын нийлбэр дүнгээс 2.9 хувиар тооцож зохицуулна.

## **6.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй ба багаж хэрэгслийн зардал**

6.3.1 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн зардалд хамаарах зардлыг шууд зардлын дүнгийн 2,5%, ажилтны хөдөлмөр хамгааллын хувцас, ажлын багаж хэрэгсэл, түүний элэгдлийн зардлыг үндсэн цалингаас 6,8 хувиар тус тус тооцоолно.

## **6.4 Ажилчдын байр, хоол, үйлчилгээний зардал**

6.4.1 Ажилчдын байр хоол, үйлчилгээний зардал нь тухайн төмөр замын замын дээд бүтцийн барилгын ажил гүйцэтгэх ажилчдын байрлах кемпийн үйл ажиллагаа, хоол хүнсэнд зориулагдсан зардал бөгөөд шууд зардлын дүнгээс материалын зардлыг хассан дүн болон удирдлага, зохион байгуулалтын зардлын нийлбэр дүнгээс 2%-р тооцно

## **6.5 Албан томилолтын зардал**

6.5.1 Албан томилолтын зардлыг нийт ажиллах хүчний хөдөлмөр зарцуулалт (хүн.цаг), машин механизм ашиглалтын нийт хэмжээ (маш.цаг)-ийн нийлбэрийг ажлын нэг өдрийн үргэлжлэх хугацаа (7.97)-д хувааж гарсан дүнг төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний /сайдын/ тушаалаар баталсан дүнгээр тогтоосон байна.

## **6.6 Даатгалын зардал**

6.6.1 Төсвийн тооцоонд даатгалын зардлын хувь хэмжээг Зам, тээвэр, аялал жуулчлалын сайдын 2007 оны 187 дугаар тушаалыг баримтлана. Үүнд:

- а) Ажиллагсдын даатгалыг тухайн жил тутамд тогтоосон нэг хүний үнэлгээнээс 0.8 хувиар;
- б) Барилга байгууламжийн даатгалыг объектын төсвийн шууд зардлын дүнгээс 0.4 хувиар;
- в) Машин механизм, тоног төхөөрөмжийн даатгалыг зөвхөн тухайн объектод ажиллах машин механизм, тоног төхөөрөмжийн балансын үнийн 0.5 хувиар тус тус тооцно.



## **6.7 Бусад зардал**

6.7.1 Технологит ажилбараас гадна нэмэлт тусгай зориулалтын барилга байгууламж барих болсон тохиолдолд захиалагч, гүйцэтгэгч байгууллагууд зардлын төрөл бүрээр тохиролцсоны үндсэнд тусад нь төсөв зохион тооцож “бусад зардал” гэсэн бүлэгт тусгана.

## **6.8 Төсөвт ашгийн хэмжээг тодорхойлох**

6.8.1 Төсөвт ашиг нь барилгын бүтээгдэхүүний үнийн нормативын хэсэг бөгөөд ажлын өртөгт нэмж тооцогдоно.

6.8.2 Гүйцэтгэгч байгууллагын төсөвт ашгийн хэмжээг шууд зардлын дүнгээс материалын зардал хассан дүн болон удирдлага, зохион байгуулалтын зардлын нийлбэр дүнгийн 20 хувиар тооцож төсөвт тусгана.

6.8.3 Төсөвт ашгийн эх үүсвэрээр байгууллага, гүйцэтгэгч аж ахуйн нэгж ажилчдын нийгмийн баталгааг хангах, үйлдвэрлэлээ хөгжүүлэх зорилгоор хийгдэх хөрөнгө оруулалтын зардал, үндсэн хөрөнгийн шинэчлэлт, эргэлтийн хөрөнгийн өсөлт, тэтгэвэр тэтгэмж, шагнал урамшуулал олгох, мэргэжилтэн бэлтгэх зэрэг зардлыг санхүүжүүлэхэд зориулагдана.

## **6.9 Төмөр замын замын дээд бүтэц барих ажлын төсөвт өртөг тодорхойлох**

6.9.1 Төмөр замын замын дээд бүтэц барих ажлын төсөвт өртөг нь ажиллах хүчний зардал, материал, тээвэр, машин механизм ашиглалтын зардлаар тодорхойлсон шууд зардал, нэмэгдэл зардал, төсөвт ашгаас бүрдэнэ. Төмөр замын замын дээд бүтэц барих ажлын төсөвт өртгийн тооцоог хавсралтад үзүүлсэн 6-р маягтын дагуу тооцохоор зохицуулсан.

## **6.10 Захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналт, зөвлөхийн үйлчилгээг хэрэгжүүлэх зардлыг тодорхойлох**

6.10.1 Захиалагчийн хяналтын зардлыг нэгдсэн төсвийн шууд зардлын дүнгээс материалын зардал хассан дүнгээс 3 хувиар тооцохоор зохицуулна.

6.10.2 Зохиогчийн хяналтын зардал нь захиалагчийн хяналтын зардалд багтсан байна.

6.10.3 Зөвлөх-хяналтын үйлчилгээг авахдаа ажлын гэрээ байгуулж ажиллах ба зөвлөх үйлчилгээний зардлыг нэгдсэн төсвийн тооцооны шууд зардлын дүнгээс материалын зардал хассан дүнгийн 3 хүртэл хувиар тооцож барилгын төсөвт өртөгт тусгана.

## **6.11 Магадалшгүй ажлын нөөц хөрөнгийг тодорхойлох**

6.11.1 Төмөр замын замын дээд бүтэц барих ажлыг гүйцэтгэх нөхцөл, төслийн шийдлийг тодотгосон үр дүнгээр ажлын явцад үүсдэг зураг төсөлд тусгагдаагүй барилгын ажлыг санхүүжүүлэх нөөц эх үүсвэрийг магадалшгүй ажлын зардал гэж

нэрлэнэ. Магадалшгүй ажлын зардлыг нэгдсэн төсвийн шууд зардлын дүнгээс 3 хувиар тооцно.

6.11.2 Магадалшгүй ажлын энэ нөөц хөрөнгийг барилгын захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагууд харилцан тохиролцсоны үндсэн дээр зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

6.11.3 Магадалшгүй ажлын зардлын нөөц хөрөнгийг дараах хүчин зүйлстэй холбогдсон нэмэгдэл зардлын нөхөн төлбөрт зарцуулна. Үүнд:

- зураг төсөлд өөрчлөлт орсон тоо хэмжээний ажлыг санхүүжүүлэх;
- зураг төслийн баримт бичиг батлагдсаны дараа илрүүлсэн төсвийн тооцооны алдааг залруулахад;
- материал эдлэхүүний хийц хэсгийг зураг төсөл зохиогчийн зөвшөөрөлтэйгөөр өөрчилсөн тохиолдолд гарах зардал;
- ажлын баримт бичгийн төслийн шийдлийн өөрчлөлтийн зөрүү.

6.11.4 Магадалшгүй ажлын зардлыг санхүүжүүлэх актыг захиалагч, зөвлөх-хяналт, зураг төсөл зохиогч болон гүйцэтгэгч байгууллагын удирдлага, талбайн инженер, төсөвчин нар гарын үсэг зурж баталгаажуулж, гүйцэтгэлийн зураг, төсвийг хийж гүйцэтгэж баталгаажуулна.

## **6.12 Нэмэгдсэн өртгийн албан татвар**

6.12.1 Төмөр замын дээд бүтцийн барилгын ажилд ногдуулах НӨАТ-ын хэмжээг Монгол Улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль"-ийн 11-р зүйлийн 11-1-д заасны дагуу барилга угсралтын ажлын дүнгээс 10 хувиар тооцож нэгдсэн төсөвт тусгана.

### **6.13.1 Норм, нормативын сан.**

6.13.2 Норм, нормативын санд төвлөрүүлэх хөрөнгийг барилга угсралтын ажлын төсөвт өртгийн дүнгээс 0,4 хувиар тооцож “норм, нормативын сангийн зардал” нэрээр нэгдсэн төсөвт тусдаа мөрөөр харуулна.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
..... оны .... дугаар сарын .....ны өдрийн  
.... дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт  
Төмөр замын замын дээд бүтэц барих  
барилгын ажлын төсөв зохиох  
дүрмийн нэгдүгээр хавсралт

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
 ..... оны .... дугаар сарын ....ны өдрийн  
 .... дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын  
 Төмөр замын замын дээд бүтэц барих  
 барилгын ажлын төсөв зохиох  
 дүрмийн нэгдүгээр хавсралт

## НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ

### АЖИЛЧДЫН ХӨДӨЛМӨР ЗАРЦУУЛАЛТ,ЦАЛИНГИЙН ЗАРДЛЫН ТООЦОО

1-р маягт

№	Үндэслэл	Ажлын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ	Ажилчдын мэргэжлийн зэрэг	Нэгж хөдөлмөр зарцуулалт хүн.цаг	Бүгд хөдөлмөр зарцуулалт хүн.цаг	Цалингийн тариф,₮	Нийт цалин,₮
1	2	3	4	5	6	7	8	9	10
							[5]*[7]		[8]*[9]
		Бүгд дүн							

### МАТЕРИАЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

2-р маягт

№	Үндэслэл	Материалын нэр	Хэмжих нэгж	Ажлын тоо хэмжээ	Материалын орц		Материалын үнэ,₮	
					Нэгж	Бүгд	Нэгж	Бүгд
1	2	3	4	5	6	7	8	9
						[5]*[6]		[7]*[8]
Бүгд дүн								

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
 ..... оны .... дугаар сарын ....ны өдрийн  
 .... дугаар тушаалын дөрөвдүгээр  
 хавсралтын Төмөр замын замын дээд  
 бүтэц барих барилгын ажлын төсөв  
 зохиох дүрмийн хоёрдугаар хавсралт

## ХОЁРДУГААР ХАВСРАЛТ

### МАТЕРИАЛЫГ АВТО ТЭЭВРЭЭР ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

3-р маягт

№	Шифр	Материалын нэр	х/н	Материалын нийт орц	Нэгж хүнд, тн	Бүх жин, тн	Ачааны зэрэг	Тээвэр		Нийт зардал, ₮
								Зай	Тариф	
1		2	3	4	5	6	7	8	9	12
						[4]*[5]				[6]*[9]
	Нийт дүн									

### МАТЕРИАЛЫГ ВАГОН ТЭЭВРЭЭР ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН ТООЦОО

3.1-р маягт

№	Шифр	Материалын нэр	х/н	Нийт материалын хэмжээ	1 вагонд ноогдох ачааны хэмжээ	Нийт Вагоны тоо	Ачааны бүлэг	Вагон тээвэр		Вагон тээврийн зардал, ₮
								Зай	Тариф	
1		2	3	4	5	6	7	8	9	10
						[4]/[5]				[6]*[9]
								Нийт дүн		

Зам, тээврийн хөгжлийн сайдын  
 ..... оны .... дугаар сарын .....ны өдрийн  
 .... дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын  
 Төмөр замын замын дээд бүтэц барих  
 барилгын ажлын төсөв зохиох дүрмийн  
 гуравдугаар хавсралт

## ГУРАВДУГААР ХАВСРАЛТ

### ТӨМӨР ЗАМЫН ЗАМ БАРИЛГА, ЗАСВАРЫН ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН БА МАШИН МЕХАНИЗМЫН 1 МАШ/ЦАГИЙН ТАРИФ

1-р хүснэгт

№	Машин механизм	1 цагийн тариф /төгрөг/
<b>1. Зүтгүүр</b>		
<b>1.1. ОХУ-д үйлдвэрлэсэн</b>		
1	2ТЭ25КМ	720,508
2	2ТЭ116УД	796,990
3	2ТЭ116УМ	845,324
4	2М62ММ	593,464
5	М62УМ	334,834
6	Загал	470,618
<b>1.2. БНХАУ болон АНУ-д үйлдвэрлэсэн</b>		
7	Evolution	725,094
8	СКД4В	
<b>2. Төмөр замын Зам барилга, засварын хөдлөх бүрэлдэхүүн, механизм</b>		
<b>2.1. ОХУ-д үйлдвэрлэсэн</b>		
9	Кран, 25м үе тавигч – УК, КЖУ	6,152,000
10	Моторт тавцан, зам тавигч краны-МПД	677,300
11	Тавцант вагон, өргөн царигийн тээврийн, өнхрүүлэгтэй-УСО	272,800
12	Платформ, 71тн	272,800
13	Машин, замыг тохируулах-чигжигч ВПО-3-3000	7,799,000

14	Машин, замыг тохируулах-чигжигч- чиг татах – ВПР-02М	7,805,000
15	Машин, замыг тохируулах-чигжигч- чиг татах - ВПРС	8,039,500
16	Машин, замын чиг татах - ПРБ	7,712,000
17	Машин, төмөр замыг балластлахад зориулсан – ЭЛБ4С	7,714,500
18	Дрезин – ДГКу	4,653,300
19	Кран, Төмөр зам дээр өөрөө явагч – 16/25 - КЖДЭ	4,672,459
20	Зам хэмжигч вагон	359,800
21	Сэв шалгах вагон	317,500
22	Кран, гүүрэн – ККС-10	272,456
23	Кран, гүүрэн – ККС-20	406,490
<b>2.2. БНХАУ-д үйлдвэрлэсэн</b>		
24	25м үе тавигч кран – PG	6,152,000
25	Машин, Зам чигжигч - DC32W-1520.	
26	Машин, Замын динамик тогтворжуулагч - WD400W-1520	
27	Машин, Балласт цэвэрлэгч - QS2-650-1520 маркийн	
28	Машин, Балласт тохируулагч - SPZ-200-1520	
29	Дрезин, GCY220-1520	
30	Кран, гүүрэн – MG-20	406,490
<b>3. Төмөр замын тоног төхөөрөмж</b>		
31	Зөөврийн цахилгаан станц АБ-2	42,400
32	Компрессор	42,400
33	Дэр мод чигжигч	30,900
34	Гагнуурын аппарат	59,800
35	Зам төмөр өрөмдөгч	30,900
36	Зам төмөр тайрагч	30,900
<p>4. Шаардлагатай бусад машин, механизмын тарифыг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 31–ны өдрийн 256 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын дагуу тооцно.</p>		

**МАШИН МЕХАНИЗМ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН  
(МАШИН.ЦАГ)-ЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

4-р маягт

№	Үндэслэл	Машин механизмын нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Машин цагийн тооцоо		Машин механизмын зардал, ₮	
					Нэгж	Бүгд	Нэгж	Бүгд
1	2	3	4	5	6	7	8	9
						[5]*[6]		[7]*[8]
Нийт дүн								

**НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ЗАРДАЛ**

5-р маягт

№	Механизмын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж хүнд, тн	Нийт хүнд, тн	Зай, км	1тн/км тариф, ₮	Бүгд зардал, ₮
1	2	3	4	5	6	7	8	9
								[6]*[7]*[8]
Нийт дүн								

## ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД БҮТЦИЙН УГСРАЛТЫН АЖЛЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ТООЦОО

6-р маягт

№	Зардлын нэр	Бүгд өртөг /төгрөг/	Тайлбар
1	Ажилчдын цалин		Маягт №1-ийн 10-р баганын дүн
2	Талбайн ИТА-гийн цалин 17%		Ажилчдын цалингийн дүнгээс 17%
3	Машин механизмын операторчдын цалин 3%		Машин механизмын зардлын дүнгээс 3%
4	Нэмэгдэл цалин 37%		Ажилчдын цалингийн дүнгээс 37%
5	Алслалын нэмэгдэл цалин		[1]+[2]+[3]-ийн нийлбэр дүнгээс ...% /1-р хүснэгт, 2-р хүснэгт/
<b>6</b>	<b>Нийт цалин</b>		[1]+[2]+[3]+[4]+[5]-ийн нийлбэр дүн
7	Нийгмийн даатгалын шимтгэл 14.5%		[6]-ийн дүнгээс 14.5%
8	Машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт		Машин механизмын зардлын дүн
9	Материал		Материалын зардлын тооцооны дүн
10	Тээвэр		Тээврийн зардлын тооцооны дүн
11	Ажлын багаж хэрэгслийн элэгдлийн зардал 6.8%		[1]-ийн дүнгээс 6.8%
12	Нүүлгэн шилжүүлэх зардал		Шаардлагатай тохиолдолд нэмэлт тооцоогоор
<b>13</b>	<b>Шууд зардлын дүн</b>		[6]+[7]+[8]+[9]+[10]+[11]+[12]-ийн нийлбэр дүн
14	Удирдлага, зохион байгуулалтын зардал 63.5%		[6]-ийн дүнгээс 63.5%
15	Ашиг 20%		[13]-[9]-ялгавраас 20%
16	ХАБЭА-н үйл ажиллагааны зардал 2.5%		[13]-ийн дүнгээс 2.5%
17	Ажиллагсдын даатгал 0.8%		Нэг хүний үнэлгээнээс 0.8%
18	Барилга угсралтын даатгал 0.4%		[13]-ийн дүнгээс 0.4%
19	Машин механизм, тоног төхөөрөмжийн даатгал 0.5%		Машин механизмын балансын үнээс 0.5%
20	Албан томилолтын зардал		Хавсралт тооцоогоор
21	Ажилчдын байр, хоолны үйлчилгээний зардал 2%		[13]-[9]-ялгавраас 2%
22	Түр барилга байгууламж 2.9%		[13]-[9]-ялгавраас 2.9%
<b>23</b>	<b>Барилга угсралтын ажлын дүн</b>		[13]+[14]+[15]+[16]+[17]+[18]+[19]+[20]+[21]+[22]-ийн нийлбэр дүн
24	Захиалагчийн хяналтын зардал 3%		[13]-[9]-ялгавраас 3%
25	Зөвлөх-хяналтын зардал 3%		[13]-[9]-ялгавраас 3%
26	Магадалшгүй ажлын зардал 3%		[13]-ийн дүнгээс 3%
27	НӨАТ 10%		[23]-ийн дүнгээс 10%
28	Норм, нормативын сан 0.4%		[23]-ийн дүнгээс 0.4%
29	Бусад ажил		Шаардлагатай тохиолдолд хавсралт төсвөөр тооцно.
<b>30</b>	<b>Нийт төсөвт өртгийн дүн</b>		[23]+[24]+[25]+[26]+[27]+[28]+[29]-ийн нийлбэр дүн



Зам, тээврийн хөгжлийн сайдын  
 ..... оны .... дугаар сарын .....ны өдрийн  
 .... дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтын  
 Төмөр замын замын дээд бүтэц барих  
 барилгын ажлын төсөв зохиох  
 дүрмийн дөрөвдүгээр хавсралт

## ДӨРӨВДҮГЭЭР ХАВСРАЛТ

### ТӨМӨР ЗАМЫН ДЭЭД БҮТЭЦ БАРИХ АЖЛЫН ТӨСӨВ БОДОХОД ХЭРЭГЛЭХ АЖИЛЛАХ ХҮЧНИЙ /ЗАМЧИН/ ЦАЛИНГИЙН ЦАГИЙН ТАРИФ

(төгрөг)

2-р хүснэгт

№	ЗЭРЭГ	I	II	III	IV	V	VI
		49.464	64.285	84.066	108.79	148.353	
1	0.0	<b>4944.88</b>	<b>5439.52</b>	<b>6082.37</b>	<b>6923.03</b>	<b>8010.93</b>	<b>9494.46</b>
2	0.1	4994.34	5503.81	6166.44	7031.82	8159.28	
3	0.2	5043.81	5568.09	6250.50	7140.61	8307.64	
4	0.3	5093.27	5632.38	6334.57	7249.40	8455.99	
5	0.4	5142.74	5696.66	6418.63	7358.19	8604.34	
6	0.5	5192.20	5760.95	6502.70	7466.98	8752.70	
7	0.6	5241.66	5825.23	6586.77	7575.77	8901.05	
8	0.7	5291.13	5889.52	6670.83	7684.56	9049.40	
9	0.8	5340.59	5953.80	6754.90	7793.35	9197.75	
10	0.9	5390.06	6018.09	6838.96	7902.14	9346.11	

### ТӨМӨР ЗАМЫН ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН АШИГЛАН ЗАДГАЙ АЧААНЫ АЧИЛТ, БУУЛГАЛТЫН ТАРИФ

3-р хүснэгт

№	Нэр	Хэмжээ	Үнэлгээ, төг	
			Ачих	Буулгах
1	Хоппер-дозатор вагон ашиглан задгай ачаа буулгах	1м <sup>3</sup>	11164	
2	Думкар вагон ашиглан задгай ачаа буулгах	1м <sup>3</sup>	10080	